Хууль зүйн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх зорилгоор ХЗДХС-ын 2024 оны А/64 дүгээр тушаалаар Ажлын хэсэг байгуулж, “Хууль зүй, дотоод хэргийн салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг сайдын А/180 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.

Тус яамны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны санхүүгийн тайланг хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан

бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэн 2026 оны 3/453 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Аудитын явцад Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгүүлж аудит хийсэн.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,094,097.4 мянган төгрөгөөр буюу 27.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,963,907.9	1,803,293.1	(1,160,614.8)
Авлага	355.5	143,844.2	143,488.6
Бараа материал	5,853,028.2	831,263.3	(5,021,764.9)
Үндсэн хөрөнгө	13,133,310.0	13,078,103.6	(55,206.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>21,950,601.6</b>	<b>15,856,504.2</b>	<b>(6,094,097.4)</b>
Өр төлбөр	2,864,019.8	1,894,393.1	(969,626.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	19,086,581.8	13,962,111.1	(5,124,470.7)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>21,950,601.6</b>	<b>15,856,504.2</b>	<b>(6,094,097.4)</b>

Эх сурвалж: Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,803,293.1 мянган төгрөг болж, тайлант хугацаанд барьцаа хөрөнгийн дансанд 7 арга хэмжээний 676,652.3 мянган төгрөг байршуулж, 31 арга хэмжээний 1,646,279.1 мянган төгрөгийг чөлөөлснөөс шалтгаалан өмнөх оноос 1,160,614.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлагын үлдэгдэл 143,844.2 мянган төгрөг болж, барьцаа хөрөнгийн дансны 91,100.0 мянган төгрөг, ахмадын сангийн 52,744.1 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлснийг авлагаар тооцсоноос шалтгаалан өмнөх оноос 143,488.6 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Бараа материалын үлдэгдэл 831,263.3 мянган төгрөг болж, тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалт, урсгал төсвөөс бэлтгэсэн 14,045,308.7 мянган төгрөг, үнэ шинэчлэн тогтоосон, үнэ төлбөргүй хүлээн авсан 3,995.0 мянган төгрөг, нийт 14,049,303.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэж, шилжүүлсэн 18,512,275.9 мянган төгрөг, үйл ажиллагаанд зарцуулсан 517,256.2 мянган төгрөг, 41,536.6 мянган төгрөгийн бараа материал акталснаас шалтгаалсан өмнөх оноос 5,021,764.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 13,078,103.6 мянган төгрөг болж, тайлант онд урсгал төсвөөс худалдан авсан 99,514.1 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан, үнэ шинэчлэн тогтоосон, балансаас баланст шилжүүлсэн зэрэг нийт 656,068.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна. Тухайлбал, ТӨБЗГ-ын 2025 оны 108, 824, 418 дугаар тогтоол, А-2/2417 албан бичгээр 268,057.1 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн үндсэн хөрөнгийг бүртгэх зөвшөөрөл олгосон, ТӨБЗГ-ын 2025 оны 367, 507 дугаар тогтоолоор 388,011.7 мянган төгрөгийн хөрөнгийн үнэ цэнийг шинэчлэн тогтоож, ашиглалтын хугацааг сунгасан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,894,393.1 мянган төгрөг болж, тайлант онд барьцаа дэнчинг олгосноос шалтгаалан өмнөх оноос 969,626.8 мянган төгрөгөөр буурчээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 13,962,111.1 мянган төгрөг болж, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Хил хамгаалах албаны 4,946,362.6 мянган төгрөгийн цахим гарцыг бараа материалын данснаас захиалагчид шилжүүлснээс шалтгаалан өмнөх оноос 5,124,470.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Биет бус хөрөнгийн дансанд 2,376.0 мянган төгрөгийн санхүүгийн программ, 99,000.0 мянган төгрөгийн цахим архив, албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн программ /e-doc/, 39,307.7 мянган

төгрөгийн удирдлагын мэдээллийн систем, 1,350.0 мянган төгрөгийн оффис лиценз, 45.8 мянган төгрөгийн гал тогооны санхүүгийн программ тус тус бүртгэлтэй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Яамны 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 30,245,480.4 мянган төгрөгийг бүрдүүлж, нийт зарлагыг 30,245,48.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас төрийн өмчит хуулийн этгээдэд олгох татаасыг 10,491,352.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 930,681.1 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 141,868.5 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 76,358.4 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 10,796.1 мянган төгрөгөөр тус тус бууруулж, нийт зардлыг 20,261,301.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь урсгал төсвийн төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй, сайдын төсвөөс зохицуулалт хийсээр байгаа нь төсвийн хэрэгжилтийн зарчим алдагдах эрсдэлтэй байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 3,354,690.0 мянган төгрөгөөр бууруулж тодотгожээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт зохицуулалт хийж, Хууль зүй, дотоод хэргийн яамны 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 19,286,761.6 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардалд 13,012,329.4 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 13,255,225.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн төслийг үндэслэлтэй, бодитой төлөвлөөгүйгээс яамны урсгал төсөв хороонд зохицуулалт хийж мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг төрийн өмчит хуулийн этгээдэд олгох татаас ангилалд өмнөх онд шилжүүлэн зарцуулсан бол тайлант хугацаанд тус ангилал 27.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 26,267,554.7 мянган төгрөг буюу 80.7 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 2,652,824.5 мянган төгрөг, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг 991,303.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 816,822.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 657,239.2 мянган төгрөг, төрийн өмчит хуулийн этгээдэд олгох татаасыг 330,020.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 279,233.2 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 263,442.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын удирдлага зохицуулалт	32,565,161.6	26,267,554.7	6,297,606.9	80.7
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	10,572,657.9	6,139,126.8	4,433,531.1	58.1
2	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	531,641.5	195,362.4	336,279.1	36.7
3	Мэдээлэл, сурталчилгааны зардал	974,000.0	256,628.8	717,371.2	26.3
4	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,630,000.0	5,299,980.0	330,020.0	94.1
5	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	245,284.0	237,446.8	7,837.2	96.8
6	Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	278,400.0	221,862.0	56,538.0	79.7
7	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	217,440.0	159,854.1	105,367.7	60.3

8	Бусад	13,278,400.0	13,255,225.3	23,174.7	99.8
9	Нэг иргэн-нэг бүртгэл хөтөлбөр	278,113.2	263,747.3	14,365.9	94.8
10	Хууль тогтоомжийг боловсруулах	451,225.0	238,321.2	219,997.3	52.0
11	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	108,000.0	-	-	-

Эх сурвалж: Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу судалгаа авч, дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Хууль зүй, дотоод хэргийн яам 2016 оноос хойш 108 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Төрийн албан хаагчдын тоог 2025 онд 9 хувиар бууруулаагүй;
- Нэг ажилтанд ногдох хоолны хөнгөлөлтийг 30.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 3.0 мянган төгрөгөөр тогтоосон;
- Хэвлэл, мэдээллийн байгууллагатай нийт 221,000.0 мянган төгрөгийн ажил, үйлчилгээний гэрээ байгуулсан байна. Үүнээс 76,800.0 мянган төгрөгөөр нийтийн эрх зүйн боловсролыг сайжруулах талаар телевизийн нэвтрүүлэг, богино хэмжээний контентыг хийсэн;
- Хууль зүй, дотоод хэргийн сайд, төрийн нарийн бичгийн даргын тушаалыг үндэслэн 14 гадаад айлчлал, томилолт, арга хэмжээнд 272,309.3 мянган төгрөгийг зарцуулснаас 15,515.3 мянган төгрөгийн буцаалт хийж, нийт 256,794.0 мянган төгрөг буюу 89.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хууль зүй, дотоод хэргийн яамны нэмэлт төсвийн дансанд Засгийн газрын нөөц сангаас 6,742,941.2 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 232.0 мянган төгрөг, нийт 6,743,173.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, бараа үйлчилгээний бусад зардалд 6,742,941.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс Засгийн газрын хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд нууцын зэрэглэлтэй арга хэмжээ, олон улсын арбитрын үйл ажиллагаатай холбоотой хуулийн зөвлөх үйлчилгээ, томилолтын зардал зэрэгт зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөө батлах тухай” 2025 оны А/08 дугаар тушаалаар урсгал болон хөрөнгө оруулалтын төсвөөр худалдан авах арга хэмжээг баталж, тайлант онд 2025 оны А/239, А/105 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Яамны 2025 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4 арга хэмжээг 13,392,000.0 мянган төгрөг, урсгал төсвийн хөрөнгөөр 14 арга хэмжээг 1,351,113.1 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 10,092,000.0 мянган төгрөгийн 3 арга хэмжээг ТХААГ нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, ХЗДХС-ын “Эрх шилжүүлэх тухай” 2025 оны А/90 тушаалаар “Тусгай тоноглол бүхий автомашин” 3,300,000.0 мянган төгрөгийн арга хэмжээг ЦЕГ-т шилжүүлж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Урсгал төсвөөс шууд гэрээ байгуулах аргаар 24,777.7 мянган төгрөгийн 3, харьцуулалтын аргаар 161,727.8 мянган төгрөгийн 7, ерөнхий гэрээгээр 51,940.0 мянган төгрөг, нээлттэй тендер шалгаруулах аргаар 727,821.2 мянган төгрөгийн 2 худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан байна.

“Эрх зүйн шинэтгэл 2 хөтөлбөрийг боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах” арга хэмжээний гүйцэтгэгч шалгараагүй, “Гадаад улсын хууль тогтоомжийг хиймэл оюун ухааны үндсэн дээр харьцуулж судлах цахим систем” арга хэмжээний гүйцэтгэгч “Чимэгэ системс” ХХК гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу санхүүгийн программд сайжруулалт хийгээгүйтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Амарсанаа, аудитор Ж.Мөнхтуул, Н.Нямсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 3/453 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 58,247,234.8 мянган төгрөгийн 1 хувиар тооцож 582,472.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль, өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлж төрийн өмчит байгууллагад олгох татаас ангилалд өмнөх онуудад төсөвт зохицуулалт хийж, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт олгосон 1,669,259.4 мянган төгрөгийн зарлагын гүйцэтгэлийг дээрх ангиллаас бууруулан татаасыг хязгаарлах арга хэмжээ авч ажилласан байна.

Түүнчлэн гадаад, дотоод томилолтын зардлыг хэмнэж бүлгийн дүнгээр хянахад 263,442.8 мянган төгрөгийн буюу 58.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мөн гадаад томилолтын зардлыг Сангийн сайдын “Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” 2011 оны 188 дугаар тушаалын хавсралтад заасан зам хоног, зочид буудлын зардлыг журмын дагуу олгож хэвшсэн байна. Мөнгөн урьдчилгааны тайлан, томилолтын тайлан, онгоцны билет, зарцуулалтын анхан шатны баримтуудыг хууль тогтоомжийн дагуу ажилтнуудаас авч архивын нэгж үүсгэсэн байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 1,083,113.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өглөө.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хуулийн хэрэгжилтэд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд горим сорил хэрэгжүүлэхэд шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг бүрэн байршуулсан тул Шилэн дансны тухай хуультай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

*1.Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, программ хангамжтай холбоотой асуудал*

Илрүүлэлт: Хууль зүй, дотоод хэргийн яамны төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэлээр тавих дотоод хяналт, тайлан, бүртгэлийг хөтөлдөг Юникус программ Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу сайжруулалт хийгдээгүй, тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-аар тайлагнахад Хууль зүйн салбарт гарч буй хүндрэлтэй асуудлыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

нийцүүлэн санхүүгийн программыг ашиглалтыг сайжруулж, санхүүгийн тайланг тайлагнахыг зөвлөж байна.

1. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд урсгал төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний 10 гэрээний 1,083,113.1 мянган төгрөгийн тендер шалгарсан хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцэл, үр дүнг байршуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23-т "худалдан авах ажиллагаа" гэж бараа худалдан авах, түрээслэх, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах ажиллагааг төлөвлөх, тендер шалгаруулалтын аргыг сонгох, үнэлгээний хороо байгуулах, тендер шалгаруулалт зохион байгуулах, тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх ажиллагааг", 48 дугаар зүйлийн 48.2-т "Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ", 48.2.7-д "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх" гэснийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд тендер шалгаруулалтын үр дүн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцлийг байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

2. Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төрийн албаны шинэчлэлийн хүрээнд төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор Хууль

зүй, дотоод хэргийн яам нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах шаардлагатай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11-т "төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах", Монгол Улсын Их Хурлын 2025 оны "Монгол Улсын Хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын Хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл"-ийн Төрийн албаны реформийн 1-т "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна

**Шийдвэрлэсэн нь:** Хууль зүй, дотоод хэргийн яамны бүтэц, чиг үүрэгт үр дүнгийн бүрэн шинжилгээ хийж, төрөөс баримталж буй бодлого, тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 52,000.0 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгуулах 15,000.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 37,000.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгч, сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Хариуцлага тооцуулах албан шаардлага	1	-	1	-	100.0
Албан шаардлага	2	15,000.0	2	15,000.0	100.0
Зөвлөмж	3	37,000.0	2	37,000.0	66.6
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>52,000.0</b>	<b>5</b>	<b>52,000.0</b>	<b>88.8</b>

ХЗДХС-ын 2021 оны А/287 дугаар тушаалаар баталсан "Хууль зүй, дотоод хэргийн салбарын албан хаагчдад орон сууцны дэмжлэг, тусламж үзүүлэх асуудлыг шийдвэрлэх нийтлэг журам"-ыг өөрчлөн найруулах талаар өмнөх онд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй тул албан шаардлага өгсөн.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Хууль зүй, дотоод хэргийн яамны мэдээлэл технологийн зардал ангилалд хийсэн сүүлийн 3 жилийн зохицуулалтыг ТЕЗ-ын төсвийн төлөвлөлтөд авч үзэх, зардал бууруулах боломжтой эсэхэд дүгнэлт хийх;

2. Сангийн сайдын 2015 оны "Журам батлах тухай" 341 дүгээр тушаалаар ТТЗ болон ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд тус сайдын 2025 оны А/3 тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь эдийн засгийн ангиллаас зөрүүтэй, ТШЗ нарын тайланг нэгтгэхэд хүндрэл үүсгэхээр байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 75,822.8 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад алдааг залрууллаа.

### **Залруулсан алдаа:**

Лицензийн төлбөр 75,822.8 мянган төгрөгийн тухай бүрийн ашиглалтыг зардалд хүлээн зөвшөөрч хасагдуулж бүртгээгүй нь УСНББОУС-3 “НББ-ийн бодлого, НББ-ийн тооцооллын өөрчлөлт ба алдаа” хэсэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 29,049.8 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 29,049.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 553,422.5 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй дүгнэлт” өглөө.

### **5.1 Албан шаардлага**

1. Бараа материалын дансанд 2021-2024 онд 3 нэр төрлийн 263,660 ширхэг 58,416.2 мянган төгрөгийн шийтгэлийн хуудсыг худалдан авч нөөцөлсөн бөгөөд тайлант онд 138,225 ширхэг шийтгэлийн хуудсыг зарцуулж, 29,049.8 мянган төгрөгийн 125,435 ширхэг үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6-т “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Лицензийн төлбөр 75,822.8 мянган төгрөгийн тухай бүрийн ашиглалтыг зардалд хүлээн зөвшөөрч хасагдуулж бүртгээгүй	1	75,822.8			1	75,822.8	1	75,822.8				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>75,822.8</b>			<b>1</b>	<b>75,822.8</b>	<b>1</b>	<b>75,822.8</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бараа материалын дансанд 2021-2024 онд 3 нэр төрлийн 263,660 ширхэг, 58,416.2 мянган төгрөгийн шийтгэлийн хуудсыг худалдан авч нөөцөлсөн бөгөөд тайлант онд 138,225 ширхэгийг зарцуулж, 29,049.8 мянган төгрөгийн 125,435 ширхэгийн үлдэгдэлтэй байна.	1	29,049.8			1	29,049.8		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>29,049.8</b>	-	-	<b>1</b>	<b>29,049.8</b>		-

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>						
Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд урсгал төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний 10 гэрээний 1,083,113.1 мянган төгрөгийн тендерт шалгарсан хуулийн этгээдтэй байгуулсан гэрээг байршуулаагүй байна.	1	1,083,113.1	1	1,083,113.1		
Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төрийн албаны реформийн хүрээнд төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яам нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах шаардлагатай байна.	1		-	1	-	

Хууль зүй, дотоод хэргийн яамны төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэлээр тавих дотоод хяналт, тайлан, бүртгэлийг хөтөлдөг Юникус программ Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу сайжруулалт хийгдээгүй байна.	1	-		-	1	
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>1,083,113.1</b>	<b>2</b>	<b>1,083,113.1</b>	<b>1-</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 105/АД1400БЧ

Улаанбаатар хот

САГ-2026/071/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд урсгал төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний 10 гэрээний 1,083,113,100.00 /Нэг тэрбум наян гурван сая нэг зуун арван гурван мянга нэг зуун/ төгрөгийн тендерт шалгарсан хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцэл, үр дүнг байршуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23-т "худалдан авах ажиллагаа" гэж бараа худалдан авах, түрээслэх, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах ажиллагааг төлөвлөх, тендер шалгаруулалтын аргыг сонгох, үнэлгээний хороо байгуулах, тендер шалгаруулалт зохион байгуулах, тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх ажиллагааг", 48 дугаар зүйлийн 48.2-т "Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ", 48.2.7-д "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх" гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд тендер шалгаруулалтын үр дүн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцлийг байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Н.Мягмар/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга /Д.Гантуяа/, ажлах шинжээч /Б.Хатантуул/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
П.АМАРСАНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тогтруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-260230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-25.Docx

1526180529



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 107/А0170064

Улаанбаатар хот

САГ-2026/871/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төрийн албаны реформын хүрээнд төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яам нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах бодлого баримталж ажиллах шаардлагатай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11-т "төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах", Монгол Улсын Их Хурлын 2025 оны "Монгол Улсын Хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын Хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл"-ийн Төрийн албаны реформийн 1-т "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль зүй, дотоод хэргийн яамны бүтэц, чиг үүрэгт үр дүнгийн бүрэн шинжилгээ хийж, төрөөс баримталж буй бодлого, тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Н.Мягмар/, Төрийн захиргаа удирдлагын газрын дарга Г.Эрдэнэбулган нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

9036107  
ATA16987  
9025031411

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
П.АМАРСАНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-764230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-13.Docx

1526180282



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 104/А0170064  
САГ-2026/271/АА-СТА-Т243

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын дансанд 2021-2024 онд 3 нэр төрлийн 263660 ширхэг, 58,416,200.00 /Тавин найман сая дөрвөн зуун арван зургаан мянга хоёр зуун/ төгрөгийн шийтгэлийн хуудсыг худалдан авч нөөцөлсөн бөгөөд тайлант онд 138225 ширхэгийг зарцуулж, жилийн эцэст 29,049,827.98 /Хорин есөн сая дөчин есөн мянган найман зуун хорин долоон төгрөг ерэн найман мөнгө /-ний 125435 ширхгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Н.Мягмар/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга /Д.Гантуяа/, ахлах мэргэжилтэн, нягтлагч бодогч /Б.Майцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ КУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
П.АМАРСАНАА